



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 333

Улаанбаатар хот

Г Даатгалын компанийн дүрмийн сангийн
доод хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 3 тэрбум төгрөг, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 10 тэрбум төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоолын нэгдүгээр заалтаар тогтоосон ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлэхдээ 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор 500 сая төгрөгөөр, 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор 500 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, дүрмийн санг бүрдүүлсэн тухай холбогдох материалаа Хороонд ирүүлэхийг даатгалын компаниудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар/С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН